

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/145/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: Ц.Мөнхзаяа

Утас: 70323108 Цахим хаяг: Munkhzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	
4.2 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Аудитын гэрчилгээ



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022 оо 22 № 199

танай _____-ны № _____-т

**ХАЙРХАНДУЛААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.ГАНХУЯГ ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь Дотуур байрны хүүхдийн хоолны зардал нормативт зардлаас хэтэрсэн, төсвийн хөрөнгөөр хувцас худалдан авч, уралдаан тэмцээн зохион байгуулсан, хөрөнгийн тооллогын бүртгэл дутуу, байгууллагын дотоод хяналтын ажлыг хангалтгүй зохион байгуулсан, үдийн цайны зардал нормативт зардлаас хэтэрсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна. 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70.4.1 эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 450, 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

015030393

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\baiguullagiiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>73876779.05</u>	<u>77820940.77</u>
33	АВЛАГА	3801800.00	496052.98
335	Бусад авлага	3801800.00	496052.98
3351	Байгууллагаас авах авлага	3801800.00	496052.98
35	БАРАА МАТЕРИАЛ	70074979.05	77324887.79
351	Түүхий эд материал	13343457.25	15428977.25
35110	Тусгай зориулалттай материал	13343457.25	15174257.25
35130	Эм боох материал		254720.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1746700.00	1958850.00
354	Хангамжийн материал	44754821.80	54742060.54
35410	Бичиг хэргийн материал	223300.00	223791.00
35460	Хүнсний материал	14422270.00	12259200.00
35470	Бусад хангамжийн материал	30109251.80	42259069.54
35600	Мал амьтад	10230000.00	5195000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1999416089.36</u>	<u>2109269227.75</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1999416089.36	2109269227.75
392	Биет хөрөнгө	1938428089.36	2048281227.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	1869985771.07	1960985771.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	-94205068.25	-150358981.93
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1630035.00	1630035.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1630035.00	-1630035.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	141047115.00	149573520.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-98652646.46	-47313370.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	134196454.83	118273584.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-79003273.23	-51193560.04
39209	Зам, гүүрийн байгууламж	45909534.90	48769534.90
39210	Хуримтлагдсан элэгдэл	-4413691.92	-5420537.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	3718999.97	3718999.97
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2375747.08	-2426119.12
39217	Ном	22220640.53	23672385.89
393	Биет бус хөрөнгө	60988000.00	60988000.00
39301	Програм хангамж	545000.00	545000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-545000.00	-545000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	60988000.00	60988000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2073292868.41</u>	<u>2187090168.52</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2073292868.41</u>	<u>2187090168.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2073292868.41	2187090168.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	559952890.74	559952890.74
51101	Өмч: - төрийн	559952890.74	559952890.74
512	Хуримтлагдсан үр дүн	850356259.64	964153559.75
51210	Өмнөх үеийн үр дүн	878866648.96	850356259.64
51220	Тайлант үеийн үр дүн	-28510389.32	113797300.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	662983718.03	662983718.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2073292868.41</u>	<u>2187090168.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	924219750.00	1155133778.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23000.00	206493415.56
120	Нийтлэг татварын бус орлого	23000.00	206493415.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		196483997.82
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		10009417.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	924196750.00	948640363.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	740056750.00	769114200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	740056750.00	769114200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25340000.00	2823563.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25340000.00	1157763.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	158800000.00	176702600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	158800000.00	176702600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	974626328.32	1041336478.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	974626328.32	1041336478.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	937561565.32	990833743.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608085700.00	611095738.55
210101	Үндсэн цалин	414614500.00	465447253.55
210102	Нэмэгдэл	144776700.00	110491596.00
210104	Урамшуулал	48694500.00	35156889.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76242327.00	79469302.30
210201	Тэтгэврийн даатгал	52126326.00	55709068.50
210202	Тэтгэмжийн даатгал	6165538.00	6197144.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	4909932.00	4411261.35
210204	Ажилгүйдлийн даатгал	1234200.00	1195621.79
210205	Эрүүл мэндийн даатгал	11806331.00	11956206.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144219810.00	172301721.00
210301	Гэрэл, цахилгаан	3957020.00	5962821.00
210302	Түлш, халаалт	139858790.00	163597900.00
210303	Цэвэр, бохир ус	404000.00	2741000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5882400.00	6256300.00
210401	Бичиг хэрэг	568600.00	753300.00
210402	Тээвэр, шатахуун	1700000.00	1784300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	419500.00	418900.00
210404	Ном, хэвлэл	23000.00	1665800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	329000.00	245800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2842300.00	1388200.00
2105	Нормативт зардал	16012700.00	21805522.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	261100.00	550752.00
210502	Хоол, хүнс	15751600.00	21254770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	867500.00	6777800.00
210604	Урсгал засвар	867500.00	6777800.00
2107	Томилот, зочны зардал	542300.00	544100.00
210702	Дотоод албан томилот	542300.00	544100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	420800.00	446300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	420800.00	446300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85288028.32	92136959.43

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1245322.50	5407900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2230400.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81812305.82	86729059.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37064763.00	50502735.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	13138450.00	25617550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12098450.00	24577550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1040000.00	1040000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	23926313.00	24885185.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23926313.00	24885185.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-50406578.32	113797300.11
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3462648.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3462648.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3462648.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-53869226.32	113797300.11

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	924196750.00	948640363.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	924196750.00	948640363.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	740056750.00	769114200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	740056750.00	769114200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25340000.00	2823563.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25340000.00	1157763.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1665800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	158800000.00	176702600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	158800000.00	176702600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	924196750.00	948640363.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	924196750.00	948640363.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	890505037.00	897925477.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608085700.00	611095738.55
210101	Үндсэн цалин	414614500.00	465447253.55
210102	Нэмэгдэл	144776700.00	110491596.00
210104	Урамшуулал	48694500.00	35156889.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76242327.00	79965355.28
210201	Тэтгэврийн даатгал	52126326.00	55709068.50
210202	Тэтгэмжийн даатгал	6165538.00	6197144.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	4909932.00	4907314.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1234200.00	1195621.79
210205	Эрүүл мэндийн даатгал	11806331.00	11956206.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144219810.00	172301721.00
210301	Гэрэл, цахилгаан	3957020.00	5962821.00
210302	Түлш, халаалт	139858790.00	163597900.00
210303	Цэвэр, бохир ус	404000.00	2741000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4430400.00	6807791.00
210401	Бичиг хэрэг	505800.00	743691.00
210402	Тээвэр, шатахуун	1700000.00	1784300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	420400.00	418900.00
210404	Ном, хэвлэл	457000.00	2124300.00

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	329000.00	245800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1018200.00	1490800.00
2105	Нормативт зардал	24252900.00	20440772.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	261100.00	712972.00
210502	Хоол, хүнс	23356700.00	19091700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	635100.00	636100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28970300.00	4000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25340000.00	0.00
210604	Урсгал засвар	3630300.00	4000000.00
2107	Томилолт, зочны зардал	542300.00	544100.00
210702	Дотоод албан томилолт	542300.00	544100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1444800.00	446300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1444800.00	446300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2316500.00	2323700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	371700.00	372900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1944800.00	1950800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33691713.00	50714885.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	9765400.00	25829700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8725400.00	24789700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1040000.00	1040000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	23926313.00	24885185.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23926313.00	24885185.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	559,952,890.74	662,983,718.03	850,356,259.64	0.00	2,073,292,868.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,952,890.74	662,983,718.03	850,356,259.64	0.00	2,073,292,868.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,952,890.74	662,983,718.03	850,356,259.64	0.00	2,073,292,868.41
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	559,952,890.74	662,983,718.03	850,356,259.64	0.00	2,073,292,868.41

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,952,890.74	662,983,718.03	850,356,259.64	0.00	2,073,292,868.41
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	113,797,300.11	0.00	113,797,300.11
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,952,890.74	662,983,718.03	964,153,559.75	0.00	2,187,090,168.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	898856750.00	874930437.00	950016800.00	921665839.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	898856750.00	874930437.00	950016800.00	921665839.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	885591350.00	865165037.00	924187100.00	895836139.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608085700.00	608085700.00	626163100.00	611829963.55
210101	Үндсэн цалин	414614500.00	414614500.00	448405500.00	465447253.55
210102	Нэмэгдэл	144776700.00	144776700.00	142675200.00	111225821.00
210104	Урамшуулал	48694500.00	48694500.00	35082400.00	35156889.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82976900.00	76242327.00	89382300.00	79965355.28
210201	Тэтгэврийн даатгал	58623100.00	52126326.00	68390500.00	55709068.50
210202	Тэтгэмжийн даатгал	6170900.00	6165538.00	5247900.00	6197144.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	4936700.00	4909932.00	4198400.00	4907314.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1234200.00	1234200.00	1049600.00	1195621.79
210205	Эрүүл мэндийн даатгал	12012000.00	11806331.00	10495900.00	11956206.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155169700.00	144219810.00	172702600.00	172301721.00
210301	Гэрэл, цахилгаан	3957020.00	3957020.00	6314700.00	5962821.00
210302	Түлш, халаалт	150808680.00	139858790.00	163597900.00	163597900.00
210303	Цэвэр, бохир ус	404000.00	404000.00	2790000.00	2741000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4430400.00	4430400.00	4435300.00	4435300.00
210401	Бичиг хэрэг	505800.00	505800.00	507600.00	507600.00
210402	Тээвэр, шатахуун	1700000.00	1700000.00	1700000.00	1784300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	420400.00	420400.00	418900.00	418900.00
210404	Ном, хэвлэл	457000.00	457000.00	458500.00	458500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	329000.00	329000.00	330100.00	245800.00

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1018200.00	1018200.00	1020200.00	1020200.00
2105	Нормативт зардал	26994750.00	24252900.00	24189700.00	19989700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	261100.00	261100.00	261900.00	261900.00
210502	Хоол, хүнс	26098550.00	23356700.00	23291700.00	19091700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	635100.00	635100.00	636100.00	636100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3630300.00	3630300.00	4000000.00	4000000.00
210604	Урсгал засвар	3630300.00	3630300.00	4000000.00	4000000.00
2107	Томилолт, зочны зардал	542300.00	542300.00	544100.00	544100.00
210702	Дотоод албан томилолт	542300.00	542300.00	544100.00	544100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1444800.00	1444800.00	446300.00	446300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1444800.00	1444800.00	446300.00	446300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2316500.00	2316500.00	2323700.00	2323700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	371700.00	371700.00	372900.00	372900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1944800.00	1944800.00	1950800.00	1950800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13265400.00	9765400.00	25829700.00	25829700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13265400.00	9765400.00	25829700.00	25829700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12225400.00	8725400.00	24789700.00	24789700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1040000.00	1040000.00	1040000.00	1040000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	898856750.00	898856750.00	898822500.00	898822500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	740056750.00	740056750.00	722119900.00	722119900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	740056750.00	740056750.00	722119900.00	722119900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	158800000.00	158800000.00	176702600.00	176702600.00
132001	Орон нутгийн төсвөөс	158800000.00	158800000.00	176702600.00	176702600.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25340000.00	2823563.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25340000.00	2823563.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25340000.00	2823563.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2372491.00
210401	Бичиг хэрэг	-	236,091.00
210404	Ном, хэвлэл	-	1,665,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	470,600.00

2105	Нормативт зардал	0.00	451072.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	451,072.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25340000.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,340,000.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25340000.00	2823563.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25340000.00	2823563.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,340,000.00	1,157,763.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,665,800.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.01.17-аас 2022.01.20-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.01.20-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.21-ний өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бага дунд боловсролын тухай хуулийн 2.1.Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино.

Тус сургууль нь 2021 онд “Чадварлаг боловсон хүчин чанартай боловсролыг эрхэмлэн нийгэмд манлайлан ажиллаж амьдрах арга ухаанд тасралтгүй суралцах чадвар бүхий иргэнийг төлөвшүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 97.5 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 0.9 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 195.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр авчээ.

Бараа материалын тодруулга тайлангаар 59.4 сая төгрөгийн материал төсвийн хөрөнгөөр, 0.08 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр бэлтгэж 62.1 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

Тайлант онд 496.1 мянган төгрөгийн авлагатай байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 24.9 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс 769.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 179.1 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 2.8 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 148 мэдээллийг ил тод мэдээлсэн, 15 мэдээллийн хугацаа хоцорсон байна

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчил болох ахмадын сангийн үлдэгдэл 908.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, ном тоологдоогүй, үдийн цайны зардал нормтивт зардлаас хэтэрсэн зөрчил дахин гарсан байна.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 25897.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа зөрчил гараагүй.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын дотоод хяналт шалгалтын зөвлөлийн ажлыг сайжруулах талаар.

1.1. Илрүүлэлт:

Байгууллага нь дотоод хяналт шалгалтын нэгжтэй боловч хяналт шалгалт бүрэн хэрэгжээгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллахад эрсдэл үүсэж байна..

1.3. Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-1. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж дотоод хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх 1 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль	6	25.9					5	25.9	1	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Ц.МӨНХЗАЯА



2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 22-НИЙ ӨДӨР

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн мэлт

Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ЭВА-2022/145/НА-СТА-ТШЗ

Байгууллагын нэр: Хайрхандуулам сумын Ерөнхий боловсролын сургууль

№	Ажил гүйцээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагач байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харуу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагач байгууллагын	
								Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Урсгал зардал	Дотуур байрны хүүхдийн хоолны зардал нормативт зардлаас хэтэрсэн байна	3846.8	албан шаардлага	Санал байхгүй.	Төсвийн тухай хуулийн 6.4.1 "Төсвийг үр ашгтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах, Монгол Улсын засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4" албаны болон ажлын дүрэмт хуучин худалдан авалтыг зохион байгуулахгүй байх, 1.6 Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцэн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх	албан шаардлага	Захирал Нягтлан Бодогч	С.Ганхуяг М.Жавзандулам
2	Дотоод хяналтын тогтолцоо	Байгууллагын дотоод хяналт, шалгалтын ажил хангалтгүй зохион байгуулсан.	0	зөвлөмж	Санал байхгүй.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 19.2-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод аудитын нэгжэж байж болно	зөвлөмж	Захирал Нягтлан Бодогч	С.Ганхуяг М.Жавзандулам
3	Урсгал зардал	Төсвийн хөрөнгөөр хуучин худалдан авч, уралдаан тэмцээн зохион байгуулсан	1009.0	албан шаардлага	Санал байхгүй.	Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашгтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах; Монгол улсын засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4 " албаны болон ажлын дүрэмт хуучин худалдан авалтыг зохион байгуулахгүй байх, 1.6 Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцэн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх	албан шаардлага	Захирал Нягтлан Бодогч	С.Ганхуяг М.Жавзандулам
4	Өмнөх онд илэрсэн зөрчил	2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил засагдаагүй төсөвт төвлөрүүлэх ахмадын сангийн 908.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлснэй зарцуулсан	908	хариуцлага тооцох албан шаардлага	Санал байхгүй.	Төрийн аудитын тухай хуулийн 21.2. Шалгагач этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрсөн бол төлбөрийн акт тогтооно.	албан шаардлага	Захирал Нягтлан Бодогч	С.Ганхуяг М.Жавзандулам
5	Удирдлагын дээд болон дотоод хяналт	2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Тулгалаар 20562.4 мянган төгрөгийн номыг тоолоогүй, хүнсний материалыг сар бүр тоолж тооцоо бодоогүй байна. 2021 онд ном тоологддоггүй байна.	23672.4	хариуцлага тооцох албан шаардлага	Санал байхгүй.	Төрийн аудитын тухай хуулийн 21.2. Шалгагач этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрсөн бол төлбөрийн акт тогтооно.	албан шаардлага	Захирал Нягтлан Бодогч	С.Ганхуяг М.Жавзандулам
6	Урсгал зардал	2020 онд Үдийн цайны норм нормативыг мөрдөөгүйгээс 1680.0 мянган төгрөгийг хэтэрүүлж зарцуулсан. Үдийн цайны зардал нормативт зардлаас хэтэрсэн байна	1316.8	хариуцлага тооцох албан шаардлага	Санал байхгүй.	Төрийн аудитын тухай хуулийн 21.2. Шалгагач этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрсөн бол төлбөрийн акт тогтооно.	албан шаардлага	Захирал Нягтлан Бодогч	С.Ганхуяг М.Жавзандулам

25897.2

Балтгаль:

АУДИТОР

Ахуйн шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.МЭНХУЯГ

Д.САНСҮХ

Б.БАТЖАРГАЛ

Танлцаж зөвшөөрсөн:
ХАЙРХАНДУУЛАМ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.ГАНХУЯГ
НЯГТЛАН БОДОГЧ
М.ЖАВЗАНДУЛАМ

1020 100910 № 0044668



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар ӨВА-2022/МСТ/НА-СТА-Т/УБ/МСТ0351/124 Арвайхээр

Г Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын Т
сургуулийн захирал С.Ганхуяг танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгөөр 1009.0 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч, уралдаан тэмцээн зохион байгуулсан зөрчил илэрсэн.

Энэ нь "Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Монгол улсын засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 "... албаны болон ажлын дүрэмт хувцас, албан конторын тавилга худалдан авалтыг зохион байгуулахгүй байх, 1.6 засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх зэрэг заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1.Дээр дурдсан төсвийн хөрөнгөөр ажлын хувцас худалдан авсан, уралдаан тэмцээн зохион байгуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Ганхуяг, нягтлан бодогч М.Жавзандулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ
Ц.МӨНХЗАЯА



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 02 өдөр

Дугаар ӨВА-2022/145/НА-СТА-ТУМС/АМТГО 351/123 Арвайхээр

Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын
сургуулийн захирал С.Ганхуяг танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг нормативт зардлаас 3846.8 мянган төгрөгийг хэтрүүлсэн зөрчил илэрсэн.

Энэ нь "Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Монгол Улсын засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450-р тогтоолыг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг норматив зардлаас хэтрүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Ганхуяг, нягтлан бодогч М.Жавзандулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

О.БАТЖАРГАЛ
Ц.МӨНХЗАЯА





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар ДВА-2022/НХС/НА-СТА-ТММ/АК570351/22 Арвайхээр

Хайрхандулаан сумын Засаг Дарга
Ч.Ганхуяг танаа
Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 20562,4 мянган төгрөгийн номыг тоолоогүй, хүнсний материалыг сар бүр тоолж тооцоо бодоогүй, цалингийн хэмнэлтийн 892.5 мянган төгрөгийг ахмадын сан гэсэн данс нээж зориулалт бус зарцуулсан, үдийн цайны норм нормативыг мөрдөөгүйгээс 1680.0 мянган төгрөгийг хэтрүүлсэнд өгсөн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй байна

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 23672.4 мянган төгрөгийн номын тооллогын бүртгэл хийгдээгүй, ахмадын сангийн 908,0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхгүй зарцуулсан, үдийн цайны норм нормативыг мөрдөөгүйгээс 1316.8 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан зөрчил давтан гарч байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1." төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.2-д заасан "Төрийн аудитын тухай хуулийн 4 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Ганхуяг, нягтлан бодогч М.Жавзандулам нарт хуульд заасны дагуу холбогдох сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хайрхандулаан сумын Засаг Дарга Ч.Ганхуягт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Ц.МӨНХЗАЯА